



МОНГОЛ УЛС
САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ
ТОГТООЛ

2011 оны 06 сарын 30 өдөр

Дугаар 185

Улаанбаатар хот

Г “Сөдөт” ХК-ийн нэгдмэл сонирхолтой 7
хувьцаа эзэмшигчдээс гаргасан тендер
саналыг зөвшөөрөх тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6.1.1, 6.2.2, Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 11 дүгээр зүйл, Компанийн тухай хуулийн 58.1 дэх заалтыг тус тус үндэслэн Санхүүгийн зохицуулах хорооноос ТОГТООХ нь:

1. “Сөдөт” ХК-ийн нийт 175265 ширхэг гаргасан хувьцааны 83.63 хувь буюу 146,568 ширхэг хувьцааг нэгдмэл сонирхолтойгоор эзэмшигч “Азиа пасифик инвестмент партнерс лимитэд компани, АНУ-ын иргэн Ли Кашелл, Б.Цэндсүрэн нараас тус хувьцаат компанийн бусад хувьцаа эзэмшигчдийн өмчлөлд байгаа нийт хувьцааны 16.37 хувь буюу 29697 ширхэг хувьцааг нэг бүрийг нь 142 /нэг зуун дөчин хоёр/ төгрөгөөр худалдан авч тус компанийг 100 хувь эзэмшихээр тендер санал гаргасныг зөвшөөрч хүчинтэй байх хугацааг 2011 оны 6 дугаар сарын 30-ны өдрөөс эхлэн ажлын 60 хоногоор тогтоосугай.

2. 2011 оны 7 дугаар сарын 05-ны өдрийн дотор “ҮЦТТГХТ” ХХК дахь данс нь нээгдээгүй байгаа хувьцаа эзэмшигчдийн дансыг компанийн санхүүжилтээр нээлгэхийг “Азиа пасифик инвестмент партнерс лимитэд” компани /Ли Кашелл, Б.Цэндсүрэн/-д үүрэг болгосугай.

3. Холбогдох хууль, журмын дагуу тендер саналаа нийтэд сурталчилж, хуулиар хүлээсэн үүргээ хугацаанд нь биелүүлэх, тендер саналын хугацаа дуусмагц ажлын 5 хоногт багтаан тендер саналын хэрэгжилтийн тайланг Хороонд ирүүлэхийг “Азиа пасифик инвестмент партнерс лимитэд” компани /Ли Кашелл, Б.Цэндсүрэн /-д үүрэг болгосугай.

4. Тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Үнэт цаасны газар /С.Тулгаа/, олон нийтэд мэдээлэхийг Тамгийн газар /Н.Удаанжаргал/-т тус тус даалгасугай.

ДАРГА

Д.БАЯРСАЙХАН

